



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/307

Мандагловь

Аялал жуулчлалын эвентийн
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Хотод ойрхон говь" аялал жуулчлалын нэгдсэн эвент арга хэмжээг зохион байгуулах ажлын гүйцэтгэгчээр "Говийн шуранхай" аялал жуулчлалын холбоо ТББ-тай гэрээ байгуулан хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Н.Гантулга)-ын дарга нарт даалгасугай.

Хоёр. Дээрх арга хэмжээнд шаардагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

48819-902